



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/166

Мандалговь

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1, 2.1.4, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед тус сумын нутаг дэвсгэрт корона вирус (ковид-19)-ын өвчлөл ихсэж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор сумын ЭМТөвийг 500 ширхэг оношлууртай болгоход хөрөнгө зарцуулсугай.

2. Ковид-19 халдварын оношилгоонд шаардлагатай байгаа 500 ширхэг оношлуурын үнэ 4.950.000 (дөрвөн сая есөн зуун тавин мянга)-н төгрөгийг ЭМТөвийн нэмэлт санхүүжилтийн 100081420401 тоот дансанд төвлөрүүлж, Засаг даргын нөөцийн зардлаас гаргахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), Ня-Бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ ОРГИЛ